



АЛТАНБУЛАГ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.04.30 № САА-2020/04-НЯ-20  
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Алтанбулаг сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Алтанбулаг сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020580

## Дүгнэлт


Алтанбулаг сумын Ардчилсан намын хорооны Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мэрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Алтанбулаг сумын Ардчилсан намын хорооны мэрийн хөтөлбөр  
/..З... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Ардчилсан намын “Монгол хүн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэх “ЭРХЭМ ЗОРИЛГО”-ыг эрхэмлэж “ШИНЭ СҮМ”  
мөрийн хөтөлбөртэй оролцож байна.



**НЭГ. ЭДИЙН ЗАСАГ –ХӨДӨӨ АЖ АХҮЙ**

1.1. Иргэдэд газар өмчлүүлэх ажлыг нээлттэй болгож, үйлдвэрлэл үйлчилгээ, газар тариалангийн газрыг өмчлүүлэх, эзэмшиүүлэх, ашиглуулах арга хэмжээг хуулийн дагуу ил тод зохион байгуулах ажлыг сумын мэдээллийн хэрэгслээр түгээнэ.

1.2. Ноос, ноолуур, малын гаралтай түүхий эдийг орон нутагтаа бэлтгэн нийлүүлдэг аж ахуйн нэгж, иргэдийг тусгай хөтөлбөрт хамруулах замаар дэмжинэ.

1.3. Сүү, цагаан идээ боловсруулах цех, бага оврын үйлдвэр ажиллуулж байгаа иргэд, ААН-ийг төсөл хөтөлбөрт сонгон шалгаруулалтаар нээлттэй жигд хамруулах бодлого баримтлан ажиллана.

1.4 Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах хүртээмжтэй болгох зорилгоор сумандaa үйл ажиллагаа явуулж байгаа хувийн мал эмнэлгүүдийг дэмжиж хамтран ажиллана.

1.5 Төмс хүнсний ногоо тариалагчдыг ЖДҮ-ийг дэмжих сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэн зоорь, хүлэмжийн аж ахуй, ногоо даршлах, савлах цехийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж ажиллана.

**ХОЁР. НИЙГЭМ-СОЁЛ УРЛАГ, СПОРТ, БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНД**

2.1. Үндэсний өв соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх сурталчлан өвлүүлэх зорилгоор сумын иргэдийн дунд урлагийн наадам зохион байгуулж, ардын авьяастнуудыг шалгаруулан, хүүхэд залуучуудад өвлүүлэх ажлыг зохион байгуулна.

2.2. Спортын төрлүүдээр хүүхдийн авьяасыг хөгжүүлэхэд мэргэжлийн чадварлаг багш нарын дэмжлэгтэйгээр дугуйлан, секцийг тогтмол хичээллүүлэн олон улсын хэмжээний тамирчдыг төрүүлэх бодлого боловсруулж ажиллана.

2.3. Бэлтгэгдсэн тамирчдыг Олон улсын уралдаан тэмцээнд оролцоход аймаг, орон нутгийн хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хандивын аян зохион байгуулж ажиллана.

2.4. СӨБ, ЕБС-ийн багш нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарч хүүхэд, залуучуудад гадаад хэлний боловсрол олгох чиглэлээр тусгай хөтөлбөр боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ.

2.5. Сумын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанартай, хүртээмжтэй, ёс зүйтэй, иргэдэд ээлтэй болгоход шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар **шийдвэрлүүлэх** санал оруулж шийдвэрлүүлнэ.

2.6. Алтанбулаг сумандаа аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэх, аялал жуулчлалыг түшиглэн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх ажлыг энэ чиглэлийн олон жилийн туршлагатай хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана.

2.7. Хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааг эрчимжүүлэх талаарх орон нутгийн санаачилгыг аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдээр уламжлуулан шийдвэрлүүлнэ.

2.8. Хилийн худалдаа эрхлэгчид, зорчигчдын ая тухтай байдлыг хангаж зорчих хэсэг, зам талбай, ариун цэврийн байгууламж, бараа бүтээгдэхүүнээ хадгалах, борлуулах зориулалтын агуулахаар үйлчлэх ажлыг энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж аж ахуйн нэгжтэй хамтран хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. ДЭД БҮТЭЦ

3.1. Сумын төвийн шаардлагатай зам засварын ажлыг аймаг, сумын хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Ардын хувьсгалын 100 жилийн оид зориулж “Солдат толгой”-д түүх дурсгалын цогцолбор байгуулах саналыг шийдвэрлүүлнэ.

## ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ

4.1. Орон нутагтаа иргэдийн хяналттай, шударга, нээлттэй, шилэн засаглалыг бий болгоно.

4.2. Тодорхой асуудлыг хөндөж дэвшиүүлсэн тохиолдолд иргэдийн саналыг тусгасан гарын үсгийг цуглуулж, багийн иргэдийн нийтийн хурал болон сумын ИТХ хуулийн хүрээнд хэлэлцдэг болно.

4.3. Иргэдэд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн зөвлөх үйлчилгээг бий болгон, хуулийн товchoонд зуучлах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

## ТАВ. ТӨСӨВ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

5.1. Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадны аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг орон нутгийн төсөвт оруулах саналыг сум, аймгийн ИТХ-аар дамжуулан УИХ-ын гишүүдэд уламжилна.

5.2. Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ~~ийлтод~~ <sup>4317143998</sup> ~~ийлтод~~ <sup>0016</sup> ~~ийлтод~~ <sup>55</sup> нээлттэй болгоно.

